МАНАЙ СОНИНЫ III УЛИРЛЫН ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,151.434... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.07.05. Лхагва. №129 (4743) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




УЛС ТӨР

2016 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГДСЭН ТАЙЛАНД “ЗӨРЧИЛГҮЙ” ГЭХ ДҮГНЭЛТ ӨГСӨН ГЭВ

II нүүрт

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

ИРАН РУУ 2000 ТОНН ХОНИНЫ МАХ ЭКСПОРТОЛНО

V нүүрт

Дугаарын 60 мөр

## Жуулчны баазууд үнээ нэмж болохгүй

Х.НОРЖИН

Монголчууд эдүгээ зэлэн дээрээ эзнээ хүлээн дүүхэлзэх хүлэг морьд лугаа улсынхаа ерөнхийлөгчийг сонгочихоод л төрж өссөн нутаг, эцэг эх, элгэн саднаа зорин хөдөө тийш хүлгийн жолоо залахаар бэлтгэл юугаа базаагаад эхэлчихсэн байгаа. Зарим нь байгалийн үзэсгэлэнт газраар аялангаа амрахаар гэр бүлээрээ ярилцаж, хаана отоглох, аль жуулчны бааз дээр хэд хонохоо төлөвлөн тэрүүхэндээ л хөл хөөрцөг болж буй биз. Гэр бүлээрээ аялангаа амрах шиг аз жаргалтай мөч хаана байх билээ. Чухам үүний төлөө олон гэр бүл хуруу хумсаа хуйхлах шахдаг нь ч нууц биш.

Үргэлжлэл нь III нүүрт

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

## Наадмын гоёлоо ЗЭХЭЖ АМЖСАН УУ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Н.БАТЗАЯА
Б.ДАВААХҮҮ
Б.БОЛОРТУНГАЛАГ

Уул тал мөнх ногоон нөмөргөө нөмөрч, хаа нэг хур бороо шаагин зуны дунд сар гарч аль хэдийн үндэсний их баяр наадам хаяанд иржээ. Энэ өдрүүдэд хөдөө нутагт хүүхэд багачуудын гийнгоон дуу цангинаж, уяа тойрч морь шинжсэн халуун яриа өрнөж байхад хот газарт наадмын нээлтийн үйл ажиллагааны бэлтгэл ажил эд өрнөхийн зэрэгцээ наадмын гоёлууд ч аль хэдийн гарч, хэн хүний нүдийг булааж эхэллээ. Монголын уламжлалт эрийн гурван наадмыг үндэсний хувцас болох монгол дээлгүйгээр төсөөлөхийн аргагүй. Гадаад дотоодын жуулчдын нүдийг булааж, чихийг хужирлах наадмын нэгэн чимэг нь монгол дизайнеруудын ур ухаанаа гаргаж урласан монгол дээл байдаг.

Үргэлжлэл нь VI-VII нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

## ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИУДЫГ ХУВЬЧИЛЪЯ

Г.ГАНЧИМЭГ

Манай улсад одоогоор төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн тоо 100 давчихсан. Бүхэл бүтэн улсын төр өөртөө өмчтэй байж болох нь мэдээж. Тэрхүү өмчийг нь харж хамгаалан нэгдсэн байдлаар менежмент хийдэг газар бол Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар /ТӨБЗГ/. Гэтэл тус газрын дарга Ц.Ням-Осор “Өнгөрсөн онд төрийн өмчит 100 гаруй аж ахуйн нэгжээс 37 нь алдагдалтай ажиллалаа. Тиймээс ТӨБЗГ-аас эдгээр төрийн өмчит компанийн гүйцэтгэх захирлуудад хамгийн түрүүнд алдагдалгүй ажиллуул гэдэг үүрэг даалгавар өгсөн. Чадахгүй бол ажлаасаа огцор. Үгүй бол, удаа дараа алдагдалтай ажиллаж буй төрийн өмчит компаниудыг хувьчлах болно” гэдэг сануулгыг өнгөрсөн хавар өгч л байсан. Аминдаа, дураараа дарга нараа айлгаж байгаа нь тэр биз. Харин одоо зуны амралт зугаалга эхэлж, сонгуулийн дуулиан шуугианд энэ ажил дарагдаж, дарга захирлууд айх завгүй, тоох янзгүй явж байх шиг байна.

Гэхдээ ард түмний нүд сохор, чих

MNB ҮНДЭСНИЙ ТЕЛЕВИЗ

## МЭДЭГДЭЛ

МҮОНРТ нь 1992 оноос хойш явагдсан бүх сонгуульд нэр дэвшигчид болон оролцогч намуудад ижил тэнцүү боломж олгож үзэгч, сонсогчийг мэдээ, мэдээллээр хангах үүргээ нэр төртэй биелүүлж ирсэн.

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуульд ч мөн адил ОНРТ-ийн тухай хууль, Сонгуулийн тухай хуулийг баримтлан нэр дэвшигчдэд ижил тэнцүү цагийг хуваарилж, тухайлсан нэвтрүүлгийн цаг, мэдээллийн хөтөлбөрт нэр дэвшигч тус бүрт 300 минутыг олгож нэвтрүүлсэн. Бидний үйл ажиллагаа улс төрийн намууд, гадаад, дотоодын хөндлөнгийн ажиглагчид, олон нийтийн хяналтын дор явж ирсэн бөгөөд тэнцвэртэй байдлаа хадгалж чадаагүй гэсэн ямар нэгэн гомдол санал ирээгүй байна.

Ерөнхийлөгчийн сонгууль -2017 мэтгэлцээний хувьд эргэн сануулахад гурван намын Ерөнхий нарын бичгийн дарга нарыг урьж мэтгэлцээнийг МҮОНРТ-ээр явуулах урилга, өөрсдийн бэлтгэсэн мэтгэлцээний журмыг танилцуулсан.

Тухайн үед намуудын Ерөнхий нарийн бичгийн дарга нар мэтгэлцээнийг МҮОНРТ-ээр явуулахыг зөвшөөрч байгаагаа мэдэгдэж, харин мэтгэлцээн явуулах манай байгууллагын журмыг хүлээн зөвшөөрөөгүй дахин хэлэлцэхээр болсон. Үүний дараа намууд мэтгэлцээний ажлын хэсгээ томилж өөрсдийн боловсруулсан журмыг манайд хүргүүлж харилцан уулзалтуудыг 3 удаа зохион байгуулж мэтгэлцээний журмыг гурван нам тохирч, гарын үсэг зурж баталгаажуулсан болно.

Гурван намын баталсан улс төрийн мэтгэлцээний журмын дагуу асуултыг хүлээн авсан бөгөөд бусдыг гүтгэн доромжилсон, нэр төр, алдар хүндийг гутаасан агуулгатай асуултыг хүлээж авахгүйг сануулсан болно.

Иргэд, олон нийтээс утсаар 59 асуулт, электрон хаягаар 3 асуулт, цахим хуудсаар 1202 асуулт ирсэн.

06-р сарын 24-ний өдөр намуудын төлөөлөл, тухайлбал МАН-аас Д.Өнөрболор, Р.Саруул, АН-аас О.Магнай, МАХН-аас Э.Эрдэнэжамьян, н.Өлзийбат нар хүрэлцэн ирж иргэд, олон нийтээс ирсэн асуултыг хэрхэн багцлах, нэр дэвшигчдээс хэдэн асуулт асуух талаар байр суурь, санал бодлоо нэгтгэж нэр дэвшигч тус бүрт 20, мөрийн хөтөлбөрийн дагуу 20, нийтдээ 80 асуултыг баталж, хүрдэнд хийсэн.

Сонгогдсон асуултын агуулгыг өөрчлөхгүй, найруулахгүй зөвхөн үг, үсгийн алдаагүй хэвлэнэ гэдгийг гурван намын төлөөлөл зөвшилцсны дагуу МҮОНРТ редакцийн засварыг хийгээгүй болно.

Иргэд сонгогчдоос ирсэн 1200 гаруй асуулт одоо ч манай байгууллагын цахим хуудсанд байршсан хэвээр байна. Эдгээр асуултуудтай аль ч улс төрийн намын нэр дэвшигчид танилцаж, мэтгэлцээндээ бэлтгэх боломжтой байсныг энд цохон тэмдэглэж байна. Сонгуульд өрсөлдөж байгаа улс төрийн хүчнүүд сонгуулийн сурталчилгаандаа МҮОНРТ-ийг аль нэгэн намд илүү үйлчилсэн мэтээр бичлэг, эвлүүлэг хийн нийгмийн сүлжээгээр тарааж байгаа нь хууль зөрчсөн үйлдэл юм.

МҮОНРТ нь олон ургальч үзэл бодлыг хүндэтгэн ардчилал, шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, энх тайвныг сахин хамгаалах, үндэстний соёл, түүх, урлаг, ёс заншлыг хүндэтгэх, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн дээдлэх, үндэсний цөөнх, эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хөтөлбөрийн бодлоготой цорын ганц байгууллага билээ. Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж байгаа МҮОНРТ-ийг улс төрийн зорилгодоо ашиглан олон нийтийн дунд зориудаар нэр хүндийг нь гутааж байгаагаа зогсоохыг шаардаж байна. Бид улс төрийн хүчнүүдийн сонирхлыг нэгтгэж мэтгэлцээн зохион байгуулахыг гол зорилгоо болгосон бөгөөд нэр дэвшигчдийг мөрийн хөтөлбөр болон өөрсдийгөө таниулах боломж олгож, олон нийтийг зөв сонголтоо хийхэд туслах үүргээ биелүүлсэн.

УИХ, Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль бүрт МҮОНРТ-рүү дайралт хийх нь газар авч байна.

Иймд гүжир гүтгэлэг, хардлага сэрдлэг, олон нийтэд буруу сэтгэгдэл төрүүлэх хууль бус үйл ажиллагаагаа зогсоож, МҮОНРТ-ийн нийт уран бүтээлчид, ажилтан ажиллагсдаас уучлалт гуйхыг Улс төрийн намуудаас шаардаж байна.

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО ТЕЛЕВИЗИЙН ЗАХИРГАА




ХААН банк

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2360.00 | 2379.00 | ФУНТ | 3016.00 | 3115.00 |
| ЕВРО | 2659.00 | 2716.00 | РУБЛЬ | 39.00 | 41.00 |
| ИЕН | 20.83 | 21.17 | ЮАНЬ | 346.50 | 350.50 |

Худалдаа хөгжлийн банк

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2360.00 | 2379.00 | ФУНТ | 3025.00 | 3118.00 |
| ЕВРО | 2656.00 | 2739.00 | РУБЛЬ | 38.85 | 41.92 |
| ИЕН | 20.66 | 21.34 | ЮАНЬ | 346.50 | 350.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

ҮЗЭЛ БОДОЛ

# ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИУДЫГ ХУВЬЧИЛЪЯ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Гэхдээ ард түмний нүд сохор, чих дүлий, толгой дүйнгэ биш. Харин ард түмнийг тийм байгаасай гэж хүсдэг улстөрчид байхыг үгүйсгэхгүй. Учир нь хоёр том намын аль сонгуульд ялсан нь төрийн өмчин дээр ээлжлэн сандаалж, ганц нэгээс бусдыг нь алдагдалтай ажиллуулаад сурчихсан. Тэгсэн хэр нь хамгийн багадаа 5-6 сая төгрөг, томоохон компанийн захирлууд бол дунджаар 25 сая төгрөгийн цалин урамшуулал авч байгаа, хүүхдээ компанийн мөнгөөр гадаадад сургаж байсныг ард түмэн мартаагүй. Сонгуульд хүчин зүтгэсний шагнал, ялсан намын хишиг нь төрийн өмчит компаниудын дарга, захирлын зөөлөн суудал болсон нь судлаад үз дээ. Байдаггүй, бүр гайхах болов уу. Ер нь манайд болохгүй байгаа бүхэн энэ олон ТӨХК нэртэй “саалийн үнээ”-нээс болж байгаа нь тодорхой байна. Тиймээс төрийн өмчит компани, үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг хувьчилья. Гэхдээ 1990 оны цэнхэр, ягаан тасалбар шиг гоомойтолгүй, жинхэнэ утгаар нь хувьчилсан шиг хувьчилж олон нийтийн өмчит компани болгочихвол компанийн засаглал, хяналт, хариуцлагын тогтолцоо нь өндөрсөх ч юм билүү. Олон хэрэгжүүлэх зорилгоор “2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалт”-ыг Засгийн газраас баталжээ.

Харин одоо ТӨБЗГ энэхүү жагсаалтын биелэлтийг дүгнэж, хэрэгжээгүй асуудлуудыг цаашид хэрхэх талаар Засгийн газраас чиглэл аван ажиллаж буй аж. Үндсэн чиглэлийг 2017-2018 онд хэрэгжүүлэхдээ төрийн болон төрийн өмчит таван байгууллагыг бүрэн хувьчлах, найман байгууллагын




нууц биш болжээ, одоо. Ийм учраас л төр муу менежер байхаас аргагүй. Дөрвөн жилийн “нас”-тай шинэ дарга морилохдоо өөрийн багтайгаа ирж, өмнөх хүмүүсийнхээ хийж байсан ажлыг ёстой нэг самарч өгнө. Ингээд судалж суралцах гэж эхний хоёр жилийг урсгаж, сурч судалсан арга, технологио нутагшуулах гэсээр байтал дараагийн хоёр жил нь шурдхийгээд өнгөрдөг. Эцэст нь, ард түмний тавих дүн ойлгомжтой. “Тэд юу ч хийгээгүй юм чинь дараагийн хүнийг нь сонгоод үзье” гэдэг горьдлого, цөхрөл. Үр дүн нь яг адилхан. Тэрбум, тэрбумын алдагдалтай ажилласан тайлангаа зөөлөн тухтай суудлын хамт дараагийн хүндээ хүлээлгэж өгчихөөд өөрөө юу ч болоогүй юм шиг хувийн бизнес хөөж, эвсэл улстөрийн сонгуульд нэрээ дэвшүүлж, дээшээ цойлдог жишиг тогтоод байна.

Уг нь МИАТ, Эрдэнэт, Эрдэнэс Тавантолгой, Хөгжлийн банк, Хөрөнгийн бирж, ДЦС-ууд, “Оргил” рашаан сувилал гээд бас ч гэж улсдаа томоохонд тооцогдох мэргэжлийн байгууллагууд одоохондоо төрийн мэдэлд байгаа. Гэхдээ заримдаа төрөөс төрдөг тэрбумтнуудын үүр орноо засдаг өндөр дэнж нь болчихдог. Товчоор хэлбэл намын санхүүжилт, улстөрчдийн халаасыг түнтийлгэхээс өөр шид алга. Ер нь ч дэлхийн жишиг ярих дуртай манайханд хэлэхэд бусад улс оронд төрийн компани гэж байна уу, үгүй юу гэдэг оломгүй далай гэдэг сэн. Ингэснээр ард түмэн өмчтэй болж, хөрөнгийн бирж ч утгаараа ажиллах бус уу.

Уг нь эрх бүхий байгуулла-гаас нь төрийн өмчит бүх аж ахуйн нэгжийн сүүлийн гурван жилийн санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийж, чухам юунаас болж жил дараалан алдагдал хүлээгээд байгаагийн учир шалтгааныг тогтоосон байдаг. Ингээд төрийн өмчит компаниудын үйл ажиллагааг сайжруулснаар ашгийг нэмэгдүүлж чадна гэж үзээд УИХ-аас 2015 онд 70 дугаар тогтоолыг гаргажээ. Энэхүү тогтоолоор “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийг баталсан юм. Энэ нь эдийн засгийн хүндрэлтэй үед цагаа олсон шийдвэр байлаа. Уг тогтоолыг төрийн эзэмшлийн хувийг бууруулах, зургаан байгууллагад бүтцийн өөрчлөлт хийхээр тусгасан байна. Өөрөөр хэлбэл, “дарагдсан” 70 дугаар тогтоолоо ширээнийхээ нүднээс гаргаж, хэрэгжүүлж биелүүлэх ажлаа хийж эхэлнэ байгаа. Ингэж байж л төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын муу засаглалыг аварч, муухай удирдлагуудаас нь салгана. Үр дүнд нь тэрбум, тэрбумын алдагдалтай хэр нь ажилласаар л байдаг улсын үйлдвэрийн газрууд, төрийн өмчит компаниуд эмх цэгцэндээ орж, жинхэнэ бизнесийн зарчмаараа буюу “тоглоомын дүрэм”-ээрээ ажиллана. Тиймээс төр муу менежер гэдгээ албан ёсоор хүлээн зөвшөөрч, төрийн өмчит компаниудаа хурдан хувьчлахыг шаардаж байна.

Дугаарын 60 мөр

## Жуулчны баазууд үнээ нэмж болохгүй

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Чухамдаа амрангаа аялна гэдэг нь аялалынхаа маршрутыг төлөвлөж, тэр дагуу байрлалтай жуулчны баазуудад тухлангаа байгалийн сайханд баясан саатахыг хэлэх болов уу. Гэвч зорин, зорин очих жуулчны бааз нь зочдын сэтгэлд нийцэхүйц үйлчилгээ үзүүлдэг нь тун цөөн. Үнэндээ жуулчны баазууд зочдын ая тухтай байдалд анхаарал хандуулахаас илүүтэй ашиг харж, гэр, байшингийн үнийг тэнгэрт хадаадгаас байгаль орчин тэр хэрээр бохирдож сүйдэх нь бий. Учир нь өндөр үнэтэй гэр, байшинд тухалж дийлэхгүй гэр бүлүүд гол, горхи, модны сүүдэр бараадан майхан саваа барьж хэд хонохдоо тэр хавийг жорлон, хогийн цэг болгон хувиргадаг. Тэгээд ч манай улс жорлон, хогийн цэгийн дутагдалд орсон орон. Зам дагуу 100 км давхиад л нэг боловсон бие засах газар, хогийн цэгтэй байхад л байгаль орчин тэр хэрээр цэвэр цэмцгэр байна. Ийм зүйл байхгүй, хяналт тавих үүрэг бүхий аймаг, сум орон нутгийн байгаль орчны байцаагч, мэргэжлийн хяналтын мэргэжилтэн нар нь эрхэлсэн ажилдаа сэтгэл гаргадаггүйн улмаас дотоодын жуулчид дуртай газраа хоноглож, дуртай газраа бие засч, идсэн хоол, уусан архины шил, шар айрагны лааз, ариун цэврийн хэрэгсэл, бэлгэвч, хүүхдийн живх, гялгар уут зэрэг хөрсөнд шингэдэггүй ахуйн хэрэглээний зүйлүүдээ тэр чигээр нь хаячихаад аялалаа үргэлжлүүлдэг. Дээр нь энэ жил хуурайшилт ихтэй байгаагийн улмаас гал алдах магадлал маш өндөр байгааг сануулахад илүүдэх юун. Тиймээс жуулчны баазууд энэ бүхнийг бодолцон хоол ундныхаа үнийг бус гэр, байшингийнхаа ханшийг 30 хувь хүртэл бууруулах хэрэгтэй байна. Төлж дийлэмгүй өндөр үнэ хэлж, жуулчдын дургүйг хүргэснээс боломжийн санал тавих аваас эдийн засгийн эргэлт нь сайн байж, тэр хэрээр ашиг орлого нь сайн байх бус уу. Дээр нь жуулчны баазуудын мөрдөх стандарт гэж байдгийг мартаж болохгүй. Модны сүүдэр дор илжирсэн үнэртэй хэдэн гэр барьчихаад түүнийгээ бааз хэмээн нэрлэж болохгүй. Адгийн наад зах нь өглөө босоод бие засах газартай, усанд орж сүйд болдоггүй юм аа гэхэд нүүрээ бүтэн угаахуйц угаалтуууртай болбол хүнээс мөнгө салгаж болмоор санагдана. Ор дэвсгэр, цагаан хэрэгслийн тухайд бичихэд ч ичмээр. Орон дээр нь сандайлахад ч нурж ойчиж байх жишээний. Ялангуяа, Улаанбаатар хот орчмын жуулчны баазууд. Тэнд хүмүүс архидах л гэж очдог. Жуулчны бааз бус олуул нийлж архидаг газар хэмээн нэрлэхэд болохгүй гэх зүйл үгүй. Өнгөрсөн 2015 онд Улаанбаатар-Мөрөн-Хатгал чиглэл засмал замтай болнсоор дотоодын жуулчид далай ээжийг үзэх гэж хэдэн зуугаараа хөвөрсөн. Харамсалтай нь дотоодын жуулчдын хүлээж авах бэлтгэлгүйн улмаас майхан сав барих төдийхөн алга дарам газар олдохгүй тэвдсэн тухайгаа нэгэн танил маань ярьсан. Ширүүн бороо, хүйтэн салхи тавьсан тэр шөнө дөрвөн ханатай гэр 200 мянга, жижигхэн дөрвөн ортой муурын 300 мянга хүрсэн төдийгүй олдохгүй байсан гэж дуулдсан. Тэнгэрийн муухай арилж, жуулчид буцсан даруйд Хөвсгөл далайн ойр орчмын газрууд хогонд дарагдаж, далай ээжийн мандал дээгүүр хэрэглэсэн ариун цэврийн цаас хөвж байсан гэнэ билээ. Хэрэвзээ дээр дурдсанчлан гэр, майхан нь боломжийн үнэтэй байсансан бол далай ээж хогон далай болохгүй байсан бизээ. Нөгөөтэйгүүр, ар тал сайтай, мөнгөтэй нөхдүүд байгалийн аль үзэсгэлэнтэй газар, аманд жуулчны бааз байгуулдаг. Жирийн иргэн Хөвсгөл далай, Богд хан уулын аманд жуулчны бааз байгуулъя гээд холбогдох албаны хүмүүст хүсэлт гаргавал боломжгүй, дархан цаазтай газар хэмээгээд гаргах нь ойлгомжтой. Тэгсэн атлаа эрх мэдэл бүхий албан тушаалтан, мөнгөтэй хүмүүс хаа дуртай газраа жуулчны бааз, амралтын газар байгуулдаг хэдий ч төгс утгаараа ажилладаг нь гарын арван хуруунд багтахуйц. Тиймээс эх дэлхийгээ хайрлах, хойч үеийнхээ сайн сайхны төлөө буян үйлдэн гэр, байшингийнхаа үнийг эгэл ардын амьдралын түвшинтэй харьцуулан тогтоогооч гэж хүсэх гэсэн юм.



# ДЭЛХИЙ

## Францын Ерөнхийлөгчийг хөнөөхөөр төлөвлөсөн байжээ

Франц энэ сарын 14-нд Хувьсгалын өдрийн парад зохион байгуулдаг бөгөөд энэ үеэр Ерөнхийлөгч Эммануэл Макроны амийг бүрэлгэхээр төлөвлөж байсан 23 настай залууг баривчилжээ. Өөрийгөө үндсэрхэг үзэлтэн гэж нэрлэсэн залуу өнгөрсөн сарын 28-нд баривчлагдан шалгаж эхэлсэн байна. Улмаар цагдаад өгсөн мэдүүлэгтээ энэ сарын 14-нд нийслэл Парис хотноо зохион байгуулагдах парадын үеэр Ерөнхийлөгчийн амийг бүрэлгэхээр төлөвлөж байснаа хүлээжээ. Үүнээс гадна ислам, жүүдийн шашинтнууд, өнгөт арьстан, ижил хүйстнүүдийг ч хөнөөх болно гэж ярьсан байна. Залуу видео тоглоом сонирхогчдын хүдаст зэвсэг худалдаж авмаар байна гэж бичсэний дараа өөр нэгэн хэрэглэгч цагдаад мэдэгдсэнээр саатуулагджээ. Түүний машинаас гурван хутга олдсон байна.

## Интернэт тоглоомд цагийн хязгаар тогтоолоо

Бага насны хүүхдүүд бүхэл шөнийн турш онлайн тоглоом тоглох явдал сүүлийн үед дэлхий нийтийн асуудал болоод буй. Тэгвэл инженерийн технологийн "Тенсент" компани өчигдрөөс БНХАУ-д хамгийн эрэлттэй тоглоомд тооцогдож буй ухаалаг утасны онлайн тоглоомын апп болох "King Of Glory"-ыг ашиглах цагт хязгаар тогтоож, өдөрт 1-2 цаг л тоглох зохицуулалт хийж буйгаа мэдэгдсэн байна.

БНХАУ-ын насанд хүрээгүй хүүхдүүд онлайн тоглоом удаан хугацаагаар тоглох тохиолдол ихэсч, эрүүл мэндэд нь эрсдэл дагуулах болсонтой холбоотойгоор тус компани "Хүүхэд багачуудынхаа эрүүл мэндийн төлөө" ийм арга хэмжээ авч буй аж.



Интернэт тоглоомын аппын ашиг орлогоороо дэлхийд тэргүүлдэг "Тенсент" компани мэдэгдэлдээ "Эхэндээ тоглоом баяр баясал авчрах зорилттай байлаа. Гэвч цаг хугацаа өнгөрөх тусам бидний тоглоомыг тоглох хүүхэд багачуудын эцэг, эхчүүдэд баяр баясал авчрахаа больсон" гэжээ. Тус тоглоомын аппыг хэрэглэгчдийн тоо өдөртөө л 80 сая хүрдэг байна. БНХАУ-ын хэмжээнд дэлгэцийн дон туссан насанд хүрээгүй хүүхдийн тоо аль хэдийнэ 24 сая хүрсэн гэх мэдээлэл ч байгаа юм. Энэ оны дөрөвдүгээр сард л гэхэд Гуандон мужид 40 цаг тасралтгүй онлайн тоглоом тоглосон 17 настай хүүхэд цус харвасан тохиолдол гарчээ. Ямартай ч, дээрх зохицуулалтыг хийснээр 12 нас хүрээгүй хүүхэд өдөрт нэг цаг, 12-18 насны хүүхэд өдөрт хоёр цаг онлайн тоглоом тоглох боломжтой болох бөгөөд цаашдаа оройн 21:00 цагаас хойш тус аппыг ашиглах боломжгүй болгохоор ажиллаж байгаа гэнэ. Цагийн хязгаарлалт өчигдрөөс хэрэгжиж эхэлсэн байна.




# ХОЙД СОЛОНГОС АНУ-Д САНУУЛГА ӨГӨВ ҮҮ

Б.ДАВААХҮҮ

Өчигдөр АНУ Их Британиас колончлолоос тусгаар тогтнолоо олсны 241 жилийн түүхт ой тохиосон. Ерөнхийлөгчийн ээлжит сонгуульд ялалт байгуулж, АНУ-ын Ерөнхийлөгч болсон Доналд Трампын тухайд ажлаа авснаас хойшхи анхны Тусгаар тогтнолын баярын үйл ажиллагаа зохион байгуулагдсан юм.

Тэгвэл энэ өдрийн өглөө тус улсад БНАСАУ сануулга өглөө. Өмнө нь Ерөнхийлөгч Доналд Трампын улс төрийн бодлогыг Нацист Германы дарангуйлагч Адольф Гитлерийнхтэй төстэй хэмээн буруушаасан мэдэгдэл хийж байсан Хойд Солонгос улс энэ удаа тив алгасагч баллистик пуужингаа амжилттай туршсанаа бахархалтайгаар зарлалаа.

Долдугаар сарын 4 буюу АНУ-ын Тусгаар тогтнолын баярын өдрийн орон нутгийн цагаар 09:40 цагийн үед БНХАУ-тай хиллэдэг хойд Пёнган мужийн Банхёны ойролцоогоос Пхеньян тив алгасагч пуужинг Япон тэнгисийн зүг хөөргөжээ. Пуужин 40 минут орчим нисч, Японы эдийн засгийн тусгай бүсэд унасан байна. Харин Пхеньян үүний дараахан мэдэгдэл хийсэн юм. Тус улсын төрийн өмчит KCNA агентлагийн өчигдрийн Онцлох мэдээгээр Үндэсний хувцастай эмэгтэй нэвтрүүлэгч тив алгасагч "Hwasong 14" пуужингийн "түүхэн" туршилтыг тус улсын удирдагч Ким Жон Ун өөрийн биеэр үзэж сонирхсон тухай мэдээлэв. Пуужин 2802 км-ын өндөрт хөөрч, 933 км зайд тусчээ. Улмаар Хойд Солонгос улс хамгийн хүчирхэг цөмийн зэвсэгтэй орон тэдийгүй дэлхийн хаана ч хүрэх хүчин чадалтай тив алгасагч пуужинг эзэмшиж буй оршлоо. Өнөөдрийг хүртэл Ким Жон Ун цөмийн цэнэгт хошуу бүхий АНУ-ын эх газарт хүрч тусах чадалтай пуужингийн хөгжүүлэлтэд гол анхаарлаа хандуулж ирсэн билээ. Тиймдээ ч, энэ удаагийн туршилт зүгээр ч нэг алхам биш гэдгийг ажиглагчид онцолж байгаа юм. Энэ он гарсаар тус улс 11 дэх удаа пуужингийн туршилт хийжээ.

Ким Жон Уны өчигдрийн сануулгад АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп ч өөрийн байр суурийа илэрхийлээд амжив. Хэдийнээс твиттер сүлжээний идэвхтэй хэрэглэгч гэгдэг тэрбээр "Хойд Солонгос дахин пуужин харвалаа. Энэ залууд хийх илүү дээр ажил байхгүй гэж үү. Өмнөд Солонгос, Япон улсууд үүнтэй удаан эвлэрнэ гэдэгт итгэхэд бэрх. Магадгүй Хятад улс Хойд Солонгосын эсрэг том алхам хийж, энэ утгагүй явдлыг нэг мөр дуусгах байх"хэмээнжиргэж,бухимдлаа илэрхийлжээ. АНУ-Хойд Солонгосын харилцаа эдүгээ хурцадмал байгаа. Саяхан Хойд Солонгост хоригдож байсан оюутан нас барсны дараагаас улам хурцадсан юм. Доналд Трампын тухайд БНХАУ-ын даргатай тохиролцон Хойд Солонгосыг асуудлыг зохицуулах төлөвлөгөө нь бүтэлгүйтсэнийг хүлээн зөвшөөрсөн. Тиймдээ ч, шинэ төлөвлөгөө боловсруулахыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөхдөө даалгасан гэх мэдээлэл бий. Түүнчлэн, өнгөрсөн долоо хоногт БНСУ-ын шинэ Ерөнхийлөгч Мүн Жэ Инийг Цагаан ордонд хүлээн авч уулзсан бөгөөд энэ үеэр мөн Хойд Солонгосын асуудлыг хэлэлцсэн байдаг. Гэвч, Мүн Жэ Ин Пхеньянтай яриа хэлэлцээр хийх саналтай байгаагаа илэрхийлсэн ч, Д.Трамп түүнээс өөр бодолтой байснаар нэгдсэн ойлголцолд хүрч чадаагүй гэдэг. Харин ням гарагт Японы Ерөнхий сайд Шинзо Абэтэй Д.Трамп утсаар ярьж, Хойд Солонгост үзүүлэх шахалтыг улам чангатгахад санал солилцсон удаатай. Мөн удахгүй БНСУ-Япон-АНУ-ын гурван талт уулзалт болж магадгүй талаар Японы мэдээллийн агентлаг дамжуулжээ. Тэдний ярилцах гол сэдэв нь мөн л Хойд Солонгосын эсрэг авах арга хэмжээ болоолтой.

Энэ мэтээр АНУ Хойд Солонгосын эсрэг авах арга хэмжээгээ чангатгахыг эрмэлзэж байх зуурт Пхеньян тус улсын Тусгаар тогтнолын тэмдэглэлт өдрийнх нь өглөө тив алгасагч пуужин харваж, сануулга өгөөд байна.

Дашрамд сонирхуулахад, 1776 оны долдугаар сарын 4-нд Умард Америк дахь Британийн колониуд Пенсильвани муж улсын Филадельфи хотод болсон Америк тивийн хоёрдугаар конгресс дээр Их Британиас тусгаар тогтнохоо зарласан түүхэн баримт бичиг батлаж байжээ. АНУ гэсэн нэрийг албан ёсоор анх удаа хэрэглэсэн энэ өдөр ийнхүү АНУ-ын Тусгаар тогтнолын өдөр болсон түүхтэй.

## Сирийн арми 69 суурин хэт даврагчдаас чөлөөлсөн байна

Сирийн засгийн газрын цэргүүд ОХУ-ын Агаар-сансрын цэргийн хүчний дэмжлэгтэйгээр өнгөрсөн сард 12 мянга гаруй км.кв талбайг эзлэх 69 суурийг хэт даврагчдаас чөлөөлжээ. Энэ тухай Оросын Батлан хамгаалахын сайд, армийн генерал Сергей Шойгу мэдэгдлээ.Тэрбээр"Зургадугаар сарын хугацаанд Сирийн засгийн газрын цэргүүд болон ардын сайн дурынхан Оросын Агаар-сансрын цэргийн хүчний дэмжлэгтэйгээр Алеппо мужийн зүүн хойд болон Сирийн төвийн өмнөд хэсэг, Пальмира хотын районд зэвхэн зургадугаар сарын хугацаанд 12177 км.кв газар нутаг, 69 суурин газрыг хэт даврагчдаас чөлөөлөв" гэж мэдэгдсэн байна. Оросын сайдын хэлснээр, Сирийн цэргүүд Сири-Иорданийн хилийн бүс рүү урагшилсаар байгаа аж. Ингэхдээ гал зогсоох тохиролцоог мөрдөж байгаа юм байна. Үүний сацуу гал зогсоох тохиролцоонд сөрөг хүчний 228 зэвсэгт отряд нэгджээ. Өнгөрсөн зургадугаар сард 329 суурин газрын төлөөлөгчид уг тохиролцоонд нэгдэн гарын үсэг зурснаар хүлээн зөвшөөрсөн суурингуудын тоо 1864-т хүрсэн байна.


# ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2017-07.05** Материал хүлээж авах сүүлийн хугацаа: **2017-08-04**
Тендер шалгаруулалтын нэр: **Архангай, Булган, Өвөрхангай аймгуудын нутгийн зааг "Элсэн тасархай"-д аймаг дундын Замын хяналтын төвийн агаарын шугамын холболт**
Тендер шалгаруулалтын дугаар: **АТҮТ 17/026**

**"Автотээврийн үндэсний төв"** эрх бүхий тендерт оролцогчдоос **Архангай, Булган, Өвөрхангай аймгуудын нутгийн зааг "Элсэн тасархай"-д аймаг дундын Замын хяналтын төвийн агаарын шугамын холболт** -ыг гүйцэтгэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 50000 төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Сангийн болон түршлагын дараах шаардлагыг хангасан байна.

- Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 онуудын борлуулалтын орлого өссөн дүнгээр аль нэг жилд 140 сая төгрөгнөөс багагүй байна.
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: Тендер санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.
- Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:.
- Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 онуудын аль нэг жилд ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа бие даан гүйцэтгэсэн байна.
- Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:

Барилга, хот байгуулалтын яамны: 2.2.2. Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, Холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиолын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт /хуучнаар бол 2.2.2, 2.2.4, 2.2.9/ Эрчим хүчний яамны: 3.2.1. Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар /0.4-10кВ/. Тухайн ажлын шаардлагыг хангахуйц Барилга, хот байгуулалтын яамны тусгай зөвшөөрөлтэй байж болно /дүйцүүлнэ/.

Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн 2 хувиар тооцож тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2017 оны 08-р сарын 04 -ний өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 08-р сарын 04 -ний өдрийн 10 цаг 30 минутад** нээнэ.

Гадаадын этгээд оролцохгүй
Дотоодын давуу эрх тооцохгүй
Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Тээвэрчдийн гудамж, Өөрийн байр, 2-р давхар, 207 тоот Худалдан авалт хариуцсан ахлах мэргэжилтэн Ж.Банзрагч, 88280448**


ЕСБХБ-НЫ ХЭВЛЭЛИЙН МЭДЭЭ

## ЕСБХБ Монголын Тера Экспресс тээвэр, ложистикийн компанид санхүүжилт олгоно.

Монгол улсын ложистикийн салбарт тэргүүлэгч Тера Экспресс компанийн үйл ажиллагааг өргөжүүлэхээр 7.6 сая ам.долларын санхүүжилтийг олгохоор боллоо.

**ШУУД ТҮГЭЭХ**
www.ebrd.com/news
Огноо: 2017/06/19
Холбоо барих: Свитлана Пиркало
Утас: +44 780 2510751
И-мэйл: svitlana.pyrkalo@ebrd.com
Twitter: @pyrkalo

Түлхүүр үгс: ЕСБХБ, Монгол Улс, Терра Экспресс, тээвэр, ложистик

Хэл: Англи, Орос, Монгол




ЕСБХБ нь Монгол Улсын дэлхийн эдийн засгийн хамтын ажиллагааг дахь оролцоог дэмжиж, Монголын ложистикийн салбарт тэргүүлэгч Тера Экспресс компанид 7.6 сая ам.долларын санхүүжилтийг олгохоор боллоо.

Тус хамтын ажиллагаа нь ЕСБХБ-аас тодорхойлсон эдийн засгийн тогтвортой байдлыг бүрдүүлэгч шилжилтийн дараах зургаан үзүүлэлтийг хангаж ажилласан юм. Эдгээр үзүүлэлтэд тогтвортой хөгжил, ногоон бизнес, өрсөлдөх чадвар, засаглалын сайн тогтолцоо, оролцоо багтдаг.

ЕСБХБ-аас олгож буй энэхүү зээл нь Монгол Улсын тээврийн салбарт хийж буй анхны төсөл юм. Дээрх санхүүжилтийн төсөл нь 2 үе шаттай хийгдэх бөгөөд тус компанийн тайлан тэнцэлд бүтцийн өөрчлөлт хийх замаар компанийн өргөжин тэлэх үйл явцад дэмжлэг үзүүлнэ.

Тера Экспресс нь 2011 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд олон тэрбум долларын уул уурхайн төсөл болох Оюу Толгой компанитай хамтарч ажилласнаар эрэлт хэрэгцээ нь өсч, үйл ажиллагаа нь хурдацтай өргөжих төлөвтэй байна.

Мөн Тера Экспресс нь экспортын тээврийн үнэ цэнийг нэмэгдүүлэх гол үүргийг гүйцэтгэхээс гадна, шинэ тоглууд дээр 35 тээврийн хэрэгсэл худалдан авах хөрөнгө оруулалтын томоохон хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг хангасан байна.

ЕСБХБ-ны ОХУ, Төв Ази, Монгол Улсын дэд бүтэц хариуцсан захирал Екатерина Мирошник хэлэхдээ: "Бид Терра Экспресс компанийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг дэмжих санхүүжилт олгох болсондоо баяртай байна. Компанийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг дэмжиж ажиллах нь Монгол Улсыг дэлхийн эдийн засгийн хамтын ажиллагаанд нэгтгэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ" гэжээ.

ЕСБХБ-ны Монгол дахь Суурин Төлөөлөгч Ирина Кравченко, "Монгол Улсад маш том боломж болоод бий. Тэр дундаа Тера Экспресс компани зэрэг шинийг санаачлагч, жижиг дунд бизнес эрхлэгчдэд энэхүү боломжийг голлон хэрэгжүүлэх зорилготой юм. Уг төсөл нь саяхан ЕСБХБ-аас баталсан Монгол Улсад баримтлах стратегийн дэд бүтэц, хувийн хэвшлийг хөгжүүлэх бодлоготой нягт уялдаатай." хэмээн тэмдэглэсэн юм.

Тера Экспресс компанийн Ерөнхий захирал Шийтүүгийн Алтанбагана, "Бид хүчин чадлаа нэмэгдүүлж, үйл ажиллагааны аюулгүй байдал, байгаль орчны стандартуудыг сайжруулах тал дээр ЕСБХБ-тай урт хугацаанд харилцан ашигтай хамтран ажиллах болсондоо баяртай байна. Энэхүү санхүүжилт нь Монголын ложистикийн салбарт зах зээлийн шинэ боломжуудыг олж авах нөхцөлийг бий болгох юм. Бид Монголын бизнесийн салбар, тэр дундаа манай компанийн ирээдүйн хөгжилд ийнхүү дэмжлэг үзүүлж байгаад ЕСБХБ-д талархаж байна" хэмээн нэмж хэлээ.

ЕСБХБ 2006 онд Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш тус улсын эдийн засгийн төрөл бүрийн салбарын 80 гаруй төсөл хөтөлбөрт нийт 1.4 тэрбум еврогийн хөрөнгө оруулалт хийгээд байна.

ЦАГ ҮЕ

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

# Иран руу 2000 тонн хонины МАХ ЭСКПОРТОЛНО

Б.БОЛОРТУНГАЛАГ

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн" зорилтыг дэвшүүлж, энэ хүрээнд Мах, сүүний анхдугаар аяныг улсын хэмжээнд өрнүүлж, олон ажил бодит биелэлээ олж хэрэгжиж байна. Тодруулбал, "Мах маркет" ХХК нь техник, технологийн шинэчлэлийг хийж, "Экспортын үйлдвэр"-ийг шинээр байгуулан ашиглалтад оруулж, олон улсын хүнсний аюулгүй байдлын стандартын дагуу нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн БНХАУ-руу экспортолж эхэллээ. Энэхүү "Экспортын үйлдвэр"-ийн үйл ажиллагаатай өчигдөр ХХААХҮ-ийн сайд П.Сэргэлэн танилцлаа. Тус үйлдвэр ашиглалтад орсноор 40 ажлын байр нэмэгдэж, сард 11300 толгой ямааны махыг дулааны аргаар боловсруулж, 100 тонн ямааны махан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, БНХАУ-ын зах зээлд гэрээгээр тасралтгүй, тогтмол нийлүүлж байгаа юм. Өөрөөр хэлбэл, жилд 135600 толгой ямааны махаар нэмүү өртөг шингээсэн 1200 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлох юм.

2017 оны эхний хагас жилд тус компани 600 тонн дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүнийг экспортолжээ. ХХААХҮ-ийн сайд П.Сэргэлэн "Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн" зорилтын хүрээнд Мах сүүний анхдугаар аяны эхлүүлж, олон ажил хийгдэж байгаагийн нэг нь махны экспорт. Махны экспортын асуудал өмнөх жилүүдэд хүндрэлтэй байсан. Харин энэ жилээс ахиц дэвшил гарч аж ахуй нэгжүүд сайн ажиллаж, монгол малын махыг зорилтот зах зээлд гаргах ажлыг амжилттай эхлүүлж байна. Засгийн газраас монгол малын махыг бөөнд нь биш зорилтот зах зээлд өндөр үнээр гарах ёстой гэсэн бодлого баримталж байна. Энэ зорилтот зах зээлийн хүрээнд "Мах маркет" ХХК Иран улс руу 2000 тонн хонины мах экспортлох гэрээ хийж эхний 140 мянган тонн махыг нийлүүлээд байна. Мөн Бүгд Найрамдах Социалист Вьетнам улсад 200 тонн ямааны махыг наймдугаар сараас эхлэн нийлүүлэхээр гэрээ байгуулсан байна. Цаашдаа Монгол Улсын Засгийн газар нэг аян зарлаад зогсохгүй. Үндэсний үйлдвэрүүдээ бодлогоор дэмжинэ. Хөрөнгө оруулалт, гадаад зах зээлтэй холбох зэрэг олон чиглэлд хамтарч ажиллана гэж үзэж байна. Тухайлбал, Вьетнам улс руу нийлүүлж буй ямааны махыг нэмэгдүүлэх боломжтой.

Удахгүй Монгол Вьетнам улс хоорондын комиссын хуралдааныг хийнэ. Энэ үеэр махны экспортыг нэмэгдүүлэх чиглэлд онцгой анхаарал хандуулна" гэдгийг онцлов. Мөн тэрээр хувийн үйлдвэрүүд байгаа нөөц боломжоо ашиглан сайн ажиллаж байна. Харин төр засгаас бүх талаар нь дэмжих ёстой.Хамгийн түрүүнд зээлийн, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих ёстой. Үйлдвэрлэлийн асуудал богино хугацааны асуудал биш. Үйлдвэрлэл дагаж олон хүн ажлын байраар хангагдаж байдаг. Зах зээл байгаад борлуулалт сайн байвал төр засаг, ХХААХҮЯ-наас урт хугацаатай бага хүүтэй үйлдвэрлэлийн зээлийг олгож дэмжлэг үзүүлнэ" гэдгийг тодотгов. Махны экспортыг дэмжиж, тогтвортой урт хугацаанд нэмэгдүүлэх, хонь ямааны махыг зорилтот зах зээлд нийлүүлсэнээр эдийн засагт эерэг нөлөө үзүүлж малчдын орлого нэмэгдэх зэрэг олон талын ач холбогдолтой. Он гарсаар үйлдвэрүүдийн мах экспортлох хүчин чадал нэмэгдэж хоёр хөршөөс гадна Исламын улс орнууд, Бүгд Найрамдах Социалист Вьетнам зэрэг улс руу мах экспортолж эхлээд байна.

Махыг дулааны аргаар боловсруулж нэмүү өртөг шингээн экспортлох нь түүхий махны экспортоос 15-20 хувиар илүү ашигтай байдаг. Мөн Өвөрхангай, Увс аймгуудад махны үйлдвэр барих ажил эхэлж, мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компаниуд үйл ажиллагаагаа өргөжүүлж, махны экспорт нэмэгдэж эхэлж байгааг байгааг дээрх жишээнээс харж болно гэдгийг "Мах маркет" ХХК-ийн үйлдвэрийн дарга С.Зориг онцолж байлаа.









Гэрэл зургийг Г.АРГУУЖИН


ХАВСРАЛТ

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдөр

**Тендер шалгаруулалтын нэр:** 2017 онд шинээр зохиосон ерөнхий боловсролын сургуулийн дунд ахлах ангийн сурах бичиг, багшийн ном тус тус худалдан авах тухай: СБШ 2017/001-014

*Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам эрх бүхий тендерт оролцогчдоос Монгол Улсын төсвийн санхүүжилтээр хэвлэх VI-IX ангийн 20 нэрийн, X, XI ангийн заавал судлах хичээлийн 22 нэрийн, сонгон судлах хичээлийн 3 нэрийн, тусгай хэрэгцээт боловсролын I-V ангийн 4 нэрийн сурах бичиг, багшийн номыг тус тус хэвлэн нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.*

Тендер шалгаруулалт нь 14 багц бүхий 1 тендер байна. **Үүнд:**

| № | Багц | Анги | № | Сурах бичгийн нэршил | Тендерийн баталгаа /төгрөгөөр/ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Багц 1 | VI | 1 | Дизайн технологи VI | 2,000,000.00 |
| 2 | | I-V | 2 | Дүрслэх урлаг, технологи I-V/*Оюуны хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын/* | |
| 3 | | VI-VII | 3 | Дүрслэх урлаг VI-VII | |
| 4 | | I-XII | 4 | Дотуур байрын багшийн дэвтэр | |
| 5 | | IV | 5 | Математик IV /Оюуны хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын/ | |
| 6 | Багц 2 | VI-VII | 1 | Хөгжим VI-VII (CD-тэй) | 1,900,000.00 |
| 7 | | V | 2 | Монгол хэл V /Оюуны хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын/ | |
| 8 | | VII | 3 | Физик VII | |
| 9 | Багц 3 | VII | 1 | Биологи VII | 1,700,000.00 |
| 10 | | | 2 | Нийгэм судлал VII | |
| 11 | | | 3 | Дизайн технологи VII | |
| 12 | Багц 4 | VII | 1 | Орос хэл VII (CD-тэй) | 1,200,000.00 |
| 13 | | VIII | 2 | Монгол хэл VIII | |
| 14 | Багц 5 | VIII | 1 | Уран зохиол VIII | 1,700,000.00 |
| 15 | | | 2 | Үндэсний бичиг VIII | |
| 16 | | | 3 | Газарзүй VIII | |
| 17 | Багц 6 | VIII | 1 | Нийгэм судлал VIII | 1,800,000.00 |
| 18 | | | 2 | Казах хэл, уран зохиол VIII | |
| 19 | | VIII-IX | 3 | Хөгжим VIII-IX (CD-тэй) | |
| 20 | | V | 4 | Монгол хэл V /Сонсголын бэрхшээлтэй сурагчдын/ | |
| 21 | Багц 7 | IX | 1 | Монгол хэл IX | 1,300,000.00 |
| 22 | | | 2 | Уран зохиол IX | |
| 23 | Багц 8 | | 3 | Үндэсний бичиг IX | 1,600,000.00 |
| 24 | | | 4 | Газарзүй IX | |
| 25 | | | 5 | Нийгэм судлал IX | |
| 26 | Багц 9 | X | 1 | Монгол хэл X | 1,600,000.00 |
| 27 | | | 2 | Уран зохиол X | |
| 28 | | | 3 | Математик X | |
| 29 | | | 4 | Биологи X | |
| 30 | Багц 10 | X | 1 | Физик X | 1,800,000.00 |
| 31 | | | 2 | Хими X | |
| 32 | | | 3 | Монголын түүх X | |
| 33 | | | 4 | Нийгэм судлал X | |
| 34 | | | 5 | Газарзүй X | |
| 35 | Багц 11 | X | 1 | Англи хэл X (CD-тэй) | 1,800,000.00 |
| 36 | | | 2 | Орос хэл X (CD-тэй) | |
| 37 | | | 3 | Бизнес судлал X | |
| 38 | | | 4 | Бизнес судлал X /Багшийн ном/ | |
| 39 | Багц 12 | XI | 1 | Монгол хэл XI | 800,000.00 |
| 40 | | | 2 | Уран зохиол XI | |
| 41 | | | 3 | Математик XI | |
| 42 | | | 4 | Монголын түүх XI | |
| 43 | Багц 13 | XI | 1 | Газарзүй XI | 1,000,000.00 |
| 44 | | | 2 | Биологи XI | |
| 45 | | | 3 | Физик XI | |
| 46 | | | 4 | Хими XI | |
| 47 | Багц 14 | XI | 1 | Англи хэл XI (CD-тэй) | 1,600,000.00 |
| 48 | | | 2 | Орос хэл XI (CD-тэй) | |
| 49 | | | 3 | Бизнес судлал XI | |
| 50 | | X-XI | 4 | Үндэсний бичиг X-XI | |

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлийг нь 50,000 (тавин мянга) төгрөгөөр худалдан авч болно. Тендерийн баримт бичгийн үнийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн сан дахь 100900015003 тоот дансанд шилжүүлнэ.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн [45] хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**

- Сүүлийн 2 жил /2015, 2016/-д гүйцэтгэсэн борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь санал болгож байгаа үнийн нийт дүнгийн 70,0 хувиас багагүй байх
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ нь санал болгож байгаа үнийн нийт дүнгийн 70 хувьтай тэнцүү байна.
- Сүүлийн 2 жил /2015, 2016 он/-ийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ.
- Сүүлийн гурван жил / 2014, 2015, 2016 он/-д энэхүү тендер шалгаруулалтаар гүйцэтгэх төсөлтэй ижил төстэй дор хаяж нэг удаагийн гэрээ хэрэгжүүлсэн байх бөгөөд түүний үнийн дүн нь санал болгож буй үнийн дүнгийн 60 хувиас багагүй байна. Санал ирүүлж буй багц тус бүрд 1 гэрээг харгалзуулан үнэлнэ.

Тендерийн баримт бичгийг худалдан авахдаа хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ. (Улсын бүртгэлийн гэрчилгээнд хэвлэлийн үйлдвэрлэл гэсэн чиглэл бичигдсэн байх.)

Тендерийн хамт дээрх хүснэгтэд заасан хэмжээтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн 10.00 цаг хүртэл Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-44, Засгийн газрын III байр, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 1 дүгээр давхар, 111 тоот өрөөнд хүлээн авах ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг хүлээн авсан өрөөнд 2017 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн 10.10 цаг т нээнэ.

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам**
**Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-44, Засгийн газрын III байр, 5 дугаар давхар, 514 тоот өрөө Сургуулийн өмнөх, бага боловсролын хэлтсийн мэргэжилтэн Ч.Ганцэцэг**
**Утас 263284, Факс: 976-11-323589**



MNB MONGOLIAN NATIONAL BROADCASTER

## СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

**Сонгон шалгаруулалтын нэр:** ERP-систем дээр суурилсан Хүний нөөц, санхүүгийн програм серверийн хамт худалдан авах
**Сонгон шалгаруулалтын дугаар:** №2017-15

МҮОНРТ-ийн Хүний нөөц, Санхүүгийн програм шинэчлэхтэй холбогдуулан ERP систем серверийн хамт худалдаж авах нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж байгаа тул нийлүүлэх эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгжийг урьж байна.

**ERP систем, санхүүгийн програмд тавигдах техникийн шаардлага.**

1. Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, УСНББОУСтандартийн дагуу хийгдсэн.
2. Тус програм нь эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл болон тусгай гэрчилгээтэй байна.
1. Байгууллагын санхүү, бүртгэлийн үйл ажиллагааг Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон сангийн яам, бусад холбогдох газруудаас гаргасан дүрэм, журмын хүрээнд хөтлөн явуулах боломжийг хангасан, цогц модуль бүхий онлайн програм хангамж байна.
3. ERP систем нь санхүүгийн модультай байх ба бусад модулыг нэмж суулгах боломжтой байна.
4. Одооны ажиллаж буй санхүүгийн програмын өгөгдлийг шинэ програмруу шилжүүлэх шаардлагатай.
5. Хэрэглэхэд хялбар, найдвартай цаашид хөгжүүлэлт хийх боломжтой байх.
6. Мэдээллийн хадгалалт нууцлалын аюулгүй байдал хангагдсан байх.
7. Хэрэглээний хамгийн энгийн, ойлгомжтой, бусад системтэй холбогдох тал дээр уян байх.
8. Үндсэн хөрөнгийн бар код унших төхөөрөмжтэй байх
9. НДД-ийн бичилт хийдэг принтерийн хамт
10. Төрийн бус байгууллагаар тайлан гаргадаг
11. Суурилуулснаас хойш бүрэн хэрэгжүүлэх хүртэл 6-с дээш сарын хугацаатай байна.

**Жич:/ Ажлын даалгавар худалдан авч болно**

**/Хүний нөөцийн програмд/ тавигдах шаардлага:**

1 .Байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагааг Хөдөлмөрийн тухай хууль,Нийгмийн даатгалын тухай хууль болон хөдөлмөрийн бусад харилцааг зохицуулахад шаардлагатай дүрэм журмын хүрээнд хөтлөн явуулах боломжийг хангасан цогц модуль бүхий онлайн програм хангамж байна.
2. Байгууллагын хүний нөөцийн нэгжийн өмнө тавигддаг хүний нөөцийн бүрдүүлэлт, цаг бүртгэл,үнэлгээ,төлөвлөлт,сургалт,сонгон шалгаруулалт, цалингийн үндсэн модультай байх.
3. Ухаалаг гар утастай зохицож ажиллах боломжтой байх.
4. Бусад модулийг нэмж суулгах боломжтой байх.
5. Мэдээллийн хадгалалт нууцлалын аюулгүй байдлыг хангасан байх.
6. Суурилуулснаас хойш бүрэн хэрэгжүүлэх хүртэл 6-с дээш сарын хугацаатай байна.

Эрх бүхий этгээд нь сонгон шалгаруулалтын материалд дараах зүйлсийг заавал тусгасан байна.

- Байгууллага, аж ахуйн нэгжийн танилцуулга, туршлага
- Байгууллага, аж ахуйн нэгж нь энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх улсын бүртгэлийн гэрчилгээтэй байх /нотариатаар баталгаажуулсан/
- Үнийн санал ирүүлэх /НӨАТ,Гаалийн болон бусад бүх зардал шингэсэн/
- Төлбөрийн хөнгөлөлт-Үнийн хөнгөлөлт
- Бараа ажил үйлчилгээ солилцоо /бартер/-ын санал ирүүлж болно.
- Татварын өргүй эсэхээ баталгаажуулах

МҮОНРТ-ээс зөвхөн тухайн сонгон шалгаруулалтад шалгарсан байгууллага, аж ахуйн нэгж, хуулийн этгээд, иргэнд эргэн хариу мэдэгдэнэ.

**Сонгон шалгаруулалттай холбоотой асуудлаар тодруулга авах бол З.Минжинбаяр /утасны дугаар -99015666 / тай холбоо барина уу.**
**Холбогдох материалаа битүүмжлэн 2017оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 16 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлнэ үү.**

**ХАЯГ: БАЯНГОЛ ДҮҮРЭГ, ХУВЬСГАЛЫН ЗАМ-3, МҮОНРТ-ИЙН БАЙР, 2 ДАВХАР, НЯГТЛАН БОДОГЧДЫН ӨРӨӨ.**

# ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

Аймгаас мэдээлж байна

ДОРНОГОВЬ АЙМАГ

## “Хүүхэд, залуучуудын цэцэрлэгт хүрээлэн” ашиглалтад орно

Дорноговь аймагт “Хүүхэд, залуучуудын цэцэрлэгт хүрээлэн”-ийн барилгын ажил эхэлсэн байна. Тодруубал, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат хотын Дархан муу мянган холбоот хошуутай байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд 560 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар өөрсдийн ажиллах хүчээр “Хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэн"-г тус аймгийн Сайншанд сумын I багт барьж байгаа ажээ. Одоогийн байдлаар бүтээн байгуулалтын ажил 80 хувьтай явагдаж байгаа бөгөөд долдугаар сарын сүүлээр ашиглалтад орох гэнэ. Ингэснээр иргэд, хүүхэд, залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, эрүүл мэнддээ хөрөнгө оруулалт хийх, цэвэр тав тухтай орчинд ажиллаж амьдрах нөхцөл бүрдэх юм байна. Тус бүтээн байгуулалтын ажилд орон нутгийн 20 гаруй ажилчид ажиллаж байгаа аж.

## Г.Халиунаа Зүүн Азийн аваргаас дөрвөн алтан медаль хүртжээ



Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо Зүүн Азийн Өсвөрийн шатарчдын аварга шалгаруулах тэмцээн есөн өдрийн турш үргэлжилж шилдгүүдээ шалгарууллаа. Уг тэмцээнд 10 орны 508 шатарчин оролцож, эрэгтэй, эмэгтэй тус бүр долоон насны ангилалаар явагдсан. Тамирчид блиц, рапид, стандарт, багийн гэсэн төрөлд өрсөлджээ. Тус тэмцээний эмэгтэй 10 насны ангилалд өсвөрийн шатарчин Дорноговь аймгийн тамирчин Г.Халиунаа дээрх бүх төрөлд түрүүлж дөрвөн алтан медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн байна. Тэрбээр энэхүү амжилтаараа Дэлхийн шатрын холбооны Дэд мастерийн /WCM/ болзол хангасан аж. Түүний дасгалжуулагчаар шатрын спортын мастер Б.Ариунбүүвээ ажиллажээ. Мөн тус тэмцээнд оролцсон 508 тамирчнаас бүх төрөлд түрүүлсэн цор ганц тамирчин болсон онцлог амжилтыг гаргасан байна.

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

## “МАК нээлттэй өдөрлөг” боллоо

Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газар болон Монголын алт компани, Хөх цавын цементийн үйлдвэр хамтран “МАК НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ”-ийг зохион байгуулжээ. Өдөрлөгт тус аймгийн Засаг дарга Г.Батсуурь, “МАК Цемент“ ХХК-ний гүйцэтгэх Захирал Б.Баттулга, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогийн хэлтсийн дарга С.Уранцэцэг, аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Д.Гансүх болон бусад албаны хүмүүс оролцлоо. Өдөрлөгийн үеэр “МАК Цемент“ ХХК-ийн танилцуулга хийгдэж Говьсүмбэр аймгаас 200 гаруй ажлын байранд ажилтан шалгаруулж авах үйл ажиллагааг зохион байгуулжээ. Мөн “МАК Цемент“ ХХК-ний гүйцэтгэх Захирал Б.Баттулга аймгийн Засаг даргатай цаашид орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, аймгийн нутаг дэвсгэрт эрчим хүч, дэд бүтцийн салбарт хэрэгжүүлэх аж үйлдвэрийн болон орон сууцны томоохон төсөл, хөтөлбөрийн хэрэгцээнд шаардагдах цемент, зуурмаг ханган нийлүүлэх, Хөх цавын Цемент, шохойн үйлдвэрт шаардагдах ажлын байр, тавигдах шаардлагын талаар тухай бүр аймгийн иргэдэд зарлан мэдээллэж байх талаар хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зуржээ. “Монголын Алт” компани нь 1993 онд анх үүсгэн байгуулагдсан, Үндэсний хөрөнгө оруулалттай, Монгол Улсын тэргүүлэх компаниудын нэг юм. Тус компани уул уурхай, барилгын материалын төсөл болон үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, агаарын тээвэр, үл хөдлөх хөрөнгө зэрэг чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг байна. “МАК” компани нь байгаль орчинд сөрөг нөлөөгүй, дэлхийд тэргүүлэх сүүлийн үеийн дэвшилтэт техник технологийг үйл ажиллагаа, үйлдвэрлэлдээ нэвтрүүлж, улс эх орныхоо хөгжил, эдийн засагт даацтай хувь нэмэр оруулах томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхлээд байгаа билээ.

## Их, дээд сургуулийн элсэлтийн бүртгэл эхэлжээ



Жил бүрийн Элсэлтийн ерөнхий шалгалтын дараа их, дээд сургуулиудын хуваарь сонголт үргэлжилдэг. Говьсүмбэр аймагт энэ жил дээд сургуулиудын 1001 хуваарь ирсэн бөгөөд 223 Улсын их, дээд сургуулийн хуваарь ирчээ. Харин хувийн их, дээд сургуулийн 778 хуваарь ирсэн аж. Тус аймгийн хэмжээнд элсэлтийн ерөнхий шалгалтыг 11 судлагдахуунаар давхардсан тоогоор 1450 сурагч өгөхөөс 1423 сурагч хамрагдаж элсэлтийн ерөнхий шалгалт 98.1 хувьтай зохион байгуулагдсан байна. Түүнчлэн МУИС-д онлайнаар бүртгүүлж 13 хүүхэд элсэн орохоор болсон бол Тайван улсын Чиен Күо технологийн Их сургуулийг “100 инженер” хөтөлбөрийн хүрээнд гурван хүүхэд элсэн орж суралцахаар болсон байна. Их, дээд сургуулийн хуваарь сонголт, бүртгэл энэ сарын 5 хүртэл үргэлжилнэ.

# НААДМЫН ГОЁЛОО



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН



**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

Түрүүч нь I нүүрт

Тэгвэл үндэсний дээл жил ирэх тусам өнгө үзэмж, чанар, материал загварын хувьд өөрчлөгдөн улам дэгжин болсоор буй. Үүнийг дагаад хэрэглэгчид ч хамгийн загварлаг басхүү чанартай дээлийг өмсөхийг хүсэх болсон. Тэр ч үүднээс Үндэсний өдөр тутмын “Монголын мэдээ” сонин жил бүр наадмын өмнө тухайн жил трэнд болж буй дээлний өнгө, загварын талаар сурвалжлан хүргэдэг уламжлалтай. Энэ удаад ч Үндэсний баяр наадмын дээлний чиг хандлагын талаар энэ удаагийн дугаарын сурвалжлагаа бэлтгэлээ.

### Сул, уналттай материалтай дээл энэ наадмын трэнд

Хааш яайшхан зассан захын задгай талбай. Худалдаа эрхлэгчдийн бараагаа агуулах том модон хайрцаг. Хоорондоо гурван алхам зай бүхий өндөр сараалжин хананы завсарт 30-40 худалдагч зогсч, хажуугаар өнгөрсөн хүмүүсийг “За, юу сонирхож явна” хэмээн халуун наранд борлосон царайндаа үл ялиг инээмсэглэн тодруулан асуух аж. Энэ бол нийслэлийн хүн амын бараг ихэнх хувь нь зорин очиж, худалдан авалт хийдэг басхүү хэсэг хувь нь амьдралаа залгуулдаг түм түжигнэж, бум бужигнасан “Нарантуул” захын дээлний худалдаа эрхлэгчдийн нэгэн өдрийн дүр зураг. Биднийг очих үед нар хэдийнэ дээш хөөрч “Нарантуул” худалдааны төвийн худалдаачид лангуун дахь бараагаа дэлгэсэн байв. Хэдий мягмар гараг таарсан ч, Үндэсний баяр наадмын амралт дөхсөн учир худалдаа эрхлэгчид амралтгүй ажиллаж буй нь энэ аж. “Нарантуул” захын задгай талбайд буюу хивс, хивсэнцэр худалддаг хэсгийн өмнөх хоёр хананы хооронд орших хэсэгхэн талбайг дээлний худалдаа эрхлэгчид дүүргэжээ. Тус тасаг руу ормогц богино өмд, эрээн цамцтай махлагдуу эрэгтэй угтан авч, “Ямар дээл сонирхож байна” гэж асуулаа. Түүнээс холгүй хар нүдний шил, даашинзтай бүсгүй ч, “янз бүрийн дээл байна шүү” хэмээн чанга дуугаар хэлээд, өөрийн хажууд өлгөсөн хэсэг дээлийг заах нь тэр.

Бид ч хэрэг явдлаа хэлж энэ жилийн хамгийн их эрэлттэй байгаа дээлний өнгө, загварын талаар асуухад дээрх эрэгтэй худалдагч “Хүмүүс энэ жил уналттай сул материалтай, босоо захтай дээл их сонирхож байна. Өнгөний тухайд улаан, шар, ногоон, цэнхэр гэсэн хурц өнгө зонхилж байна. Загвар нь хүний сонирхлоос л хамаарч байгаа. Гэхдээ урт хормойтой



...Дээлний тасагт худалдан авагчид цөөн. Сумын наадамд Монгол үндэсний дээл өмсөж оролцох гэж буй Солонгосоос ирсэн гурван жуулчин, загвар сонирхож явна гэх залуухан бүсгүй, хос дээл сонирхож яваа гэр бүлийн хоёроос өөр үйлчлүүлэгч ирсэнгүй...





дээл илүүтэй худалдан авч байна. Үнийн хувьд дээл 80-300 мянгын хооронд байгаа. Харин монгол загварын цамц 20-80 мянган төгрөгийн хооронд худалдаалагдаж байна даа. Үнийн хувьд өөрчлөгдсөн зүйл байхгүй. Яах вэ, материалаасаа шалтгаалаад үнэ нь өөр өөр хэлбэлзэж байгаа юм” гэсэн юм. “Нарантуул” захад худалдаа эрхлэгчид өөрсдөө дээлний загвар, өнгөө сонгон үйлчлүүлэгчдийн эрэлтэд нийцүүлэн урладаг бөгөөд басхүү нэг нэгнийхээ загварыг давтахгүй, өөрийн гэсэн онцлогтой байхыг эрхэмлэдэг юм байна. Бидний уулзсан сайх эрэгтэйн лангуун дахь дээл бусдаасаа материал, цэцгэн хээгээрээ ялгарах гэнэ. Цэцэгтэй торгон болон даавуун материалтай дээл тэдний онцлог брэнд. Түүнчлэн, энгэр хэсэгтээ өөр өнгийн оруулгатай Орос цэргийн хувцаснаас сэдэвлэсэн загвартай дээлийг ч урлаж байгаа аж. Худалдагч эр “Одоо чинь ялгарахгүй л бол болохгүй болсон. Энгийн загвартай дээлийг хүмүүс төдийлөн сонирхохоо больсон” гэлээ. Үндэсний баяр наадам болоход хэдхэн хоногийн хугацаа үлдсэн ч, худалдан авалт өнгөрсөн жилүүдээс муу байна гэсэн юм.

Өөр нэгэн лангууны тухайд дээлнийхээ энгэр болон хормойн хэсэгт цэцгэн хээг оруулж өгсөн байв. Харин худалдагч нь “Бусдаасаа өөр болгохын тулд хормой, энгэр хэсэг нь цэцгэн чимэглэл оруулж өгсөн. Энэ жилийн чиг хандлага нь ч гэсэн цэцэгтэй загвар зонхилж байгаа. Хээтэй дээлнүүд ерөнхийдөө гарчихсан учраас цэцгийг оруулж өгснөөрөө онцлог. Бусдаасаа

## ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

# зэхэж амжсан уу

ялгарахгүй л бол орлогогүй болно шүү дээ" гэж ярилаа. Дээлний тасагт худалдан авагчид цөөн. Сумын наадамд Монгол үндэсний дээл өмсөж оролцох гэж буй Солонгосоос ирсэн гурван жуулчин, загвар сонирхож явна гэх залуухан бүсгүй, хос дээл сонирхож яваа гэр бүлийн хоёроос өөр үйлчлүүлэгч ирсэнгүй. Нүдэн баримжаагаар 30 орчим метр үргэлжлэх ганц тасгийг хэд тойрч байж тэд сонголтоо хийж байгаа нь харагдсан. Харин худалдагч нарын дуу энд тэндгүй сонсогдож, хажуугаар өнгөрөх тоолонд нь дуудаж байлаа. Мөн өнгө дурдан хослон, хээ хуараар чимэглэсэн торгон, чисчүү, даавуун материалтай, дан болон давхар эмжээртэй янз бүрийн загварын дээлнүүд өлгөөтэй байв. Дэлхийд ховор монгол наадамдаа хэнээс ч дутахгүй өнгө үзэмжтэй сайхан харагдахыг хэн хүнгүй хүсдэг. Тэр тусмаа хөдөө орон нутгаас наадмын гоёлоо авахаар ирсэн иргэд их хатуу шалгуур тавин худалдаж авдаг гэнэ. Тэд эмжээрийн нарийн бүдүүн, танаас, ухлаадас, хойд хормойны оруулга, хавалт, дээлний материалын чанар зэргийг маш нарийн харж, худалдан авалт хийдэг нь бужигнасан олны дотор аажуу тайван гэгч нь даавууны ширхэг бүрийг тэмтрэн зогсож байгааг харахад л илт байлаа.

### “Ур Ундрах” үндэсний бахархал калиграф бичигтэй дээлийг санал болгож байна

Тухайн хүний хүссэн загвар, хэлбэр хэмжээгээр нь дахин давтагдашгүй цор ганц дээл хувцсыг урладаг олон салон байдгийн нэг нь “Ур Ундрах” компани. Үндэсний их баяр наадмыг угтан эдний хамт олон калиграф бичигтэй, чоно, морьтой чимэглэл бүхий дээлийг үйлчлүүлэгчиддээ санал болгож байгаа гэнэ. “Ур Ундрах” ХХК-ийн захирал А.Алтантуяа “Энэ жилийн үндэсний баяр наадмаар манайх Тайланд, Энэтхэг улсаас оруулж ирсэн сайн чанарын зөөлөн, биед эвтэйхэн, хүний биед ямар нэг харшил өгөхгүй цэвэр хөвөн даавуун материалаар дээл, хувцсаа оёж үйлчилж байна. Нэг хэсэг монголчууд Хүннү захтай дээл өмсдөг байсан бол өнөөдөр харьцангуй гайгүй болсон. Гэхдээ богино хүзүүтэй, махлаг бүсгүйчүүдийн тухайд захны суулт нь чөлөөтэй байдаг учраас хүннү дээлийг сонгон хийлгэж байгаа. Манайх Үндэсний баяр наадмыг тохиолдуулан монгол хүн морийг сүлдэндээ дээдэлдэг учраас морийг ханба, цэмбэнд хатгаж байгаа. Цаашдаа үүнийгээ брэнд болгож, Монгол даяар сурталчлах бодолтой байна. Бас Монгол бичигтэй цамц урлаж байгаа. Өвөл хийж байсан, одоо ч хийж байгаа. Олон аймгийн хүмүүс юу хүсэж байгааг нь мэдэхгүйгээр дагуулна гэж үгүй. Тэдний сэтгэлд ноёд, засаг төрийн ажил яв цав нийцсэн тохиолдолд улсын хөгжил ирнэ гэсэн Чингис хааны сургаалийг калиграф үсэгтэйгээр урласан. Энэ бол монгол хүний юугаар ч сольшгүй брэнд болно гэдэгт найдаж байна” гэлээ. Тус салоны Үндэсний баяр наадмын дээлний трэнд өнгөний тухайд шар, ногоон, номин цэнхэр, улбар шар, цагаан шаргал гэх мэт тод өнгө зонхилж буй гэнэ. Улирал нь урин дулаан цаг учир цэцэг дэлгэрч буй мэт номин цэнхэр, улбар шар, шар, ногоон, шаргал, улаан, цагаан зэрэг тод өнгийн дээлнүүд эрэлттэй байгаа бол өвлийн улиралд өнгөний чиг хандлага өөрчлөгддөг байна.

Мөн Ур-Ундрахын нэг онцлог нь сувдаар үндэсний хээ урлан, бүтээгдэхүүнээ чимэглэдэг юм. Тэгвэл энэ талаар А.Алтантуяа захирал “Бид сувдаар хас, ланз хээ хийдэг. Ийм дээлийг өмсөхийн тулд 2-3 сарын өмнө захиалгаа өгөхгүй бол болохгүй. Сувдныхаа ширхэг бүрийг шаглаж оёдог учраас маш чанартай. Манай Ур Ундрахынхан гар ажиллагааг эрхэмлэдэг. Цаашдаа есөн эрдэнээр чимэглэсэн дээл урлах бодолтой байгаа” гэсэн юм. Мөн тэрбээр үндэснийхээ хувцасны загварыг төдийлөн өөрчлөхийг хүсдэггүй аж. Одоогоор аль хэдийнэ захиалгаа хаасан учир наадмын гоёлоо сонгож амжаагүй иргэд тус салонд зочилж, бэлэн байгаа бараан бүтээгдэхүүнээс сонгох боломжтой юм байна. Үүний хувьд материал, хэр ажиллагаа шаардахаас хамаарч янз бүр байх бөгөөд хамгийн хямд дээл 120-130 мянга байдаг аж. Дашрамд сонирхуулахад, гадаад улс оронд ажиллаж амьдарч буй монголчууд Ур Ундрахыг ихээр сонгон үйлчлүүлдэг бөгөөд дээлэндээ калиграф бичгээр “Би Монгол”, “Хөх тэнгэр” гэх мэт үг бичүүлдэг бол зарим нь Монгол Улсынхаа газрын зураг, чоно, мориор чимэглүүлдэг байна. Тиймээс монгол хүн та ч гэсэн үндэстний онцлог, бахархлаа шингээсэн дээлийг энэ зуны наадмын гоёлоороо сонгож болох нь ээ. Түүнчлэн, эднийх малгай урладаг гэдгээрээ ч мөн онцлогтой.

### 40-ээс дээш насныханд зориулсан тусгай загвар бий гэв

*Наадмын гоёлоо хайж буй хэн бүхэнд зөвлөх дараагийн газар бол “Urban Jeans”. Үндэсний брэндийг дэлхийд гаргахыг зорилгоо болгон ажилладаг чадварлаг хамт олон Монголын үндэсний уламжлалт баяр наадамд зориулан “Хүрээ” коллекцоо гаргажээ. Энэ удаагийн коллекцийнхоо өнгө төрхийг дэлхийн загварын ертөнцийн тухайн жилийн болон улирлын өнгөний чиг хандлагыг тодорхойлдог Пантоне колор институтээс гаргасан өнгөний иж бүрдлүүдээр тодорхойлжээ. Энэ талаар “Urban Jeans” брэндийн дизайнер Б.Болортуяатай цөөн хором ярилцлаа.*

**-“Urban Jeans”үндэсний брэндийн хамт олон аль хэдийнэ наадмын “Хүрээ” коллекцоо гарган, үйлчлүүлэгч нартаа бэлэг барьжээ. Юуны өмнө коллекцийнхээ талаар танилцуулахгүй. Ямар онцлогтой вэ?**

-Манай компани үндэсний их баяр наадамд зориулан “Хүрээ” нэртэй коллекц гаргаад байна. Бид дэлхийн загварын ертөнцийн чиг хандлага болон Монголчуудын өдөр тутмын амьдралын хэв маягт тохирсон хэрэглээг судалсны үр дүнд энэхүү коллекцио гаргасан. Баяр наадмаар гэлтгүй өдөр тутам өмсөх боломжтой эхнэр, нөхөр, залуучууд, бүсгүйчүүд болон хүүхдэд зориулсан цамц, өмд, даашинзыг урлалаа. Сүүлийн үед манай улсын иргэд хос дээл, хос цамцыг илүү сонирхож байна. Тиймээс үйлчлүүлэгчдийнхээ хүсэл сонирхолд нийцүүлэн коллекцдоо хос хувцаснуудыг багтаасан.

**-Энэ жил монгол дээлний загварт ямар өнгө давамгайлж байна вэ?**

-Дэлхийн загварын ертөнцийн тухайн жилийн болон улиралын өнгөний чиг хандалгыг тодорхойлдог Пантоне колор институт гэж байгууллага бий. Уг байгууллагаас 2017 оны өнгөний чиг хандлагыг тодорхойлсон. Манай коллекцид цайвар, ягаан, усан цэнхэр гэх мэтчилэн өнгө давамгайлж байна.






















**-Залуу охид, бүсгүйчүүдэд зориулсан загварын дээл олон бий. Гэтэл 40-ээс дээш насныханд зориулсан загварын дээл төдийлөн байдаггүй. Танай коллекцид энэ насныханд зориулсан загвар байгаа юу?**

-Яах аргагүй 40-ээс дээш насны хүмүүс орхигдох гээд байдаг. Энэ насны хүмүүс ихэвчлэн мярайлаг хүмүүс байдаг учраас тэр болгон өөрт тохирсон загварын дээлийг олж чаддаггүй. Харин манай коллекцид энэ насны бүсгүйчүүдэд зориулсан загварууд бий. Тухайлбал, дэлхийн загварын чиг хандлагыг тодорхойлж буй шулуун А болон О хэлбэрийн загвартай даашинз, цамц бий. Мөн бүсгүйчүүддээ энгэр болон ар нуруун талдаа хатгамал хээг шаглаж, хүзүүний зүүлт, бүс, цүнх зэрэг аксисуараар тодотгон чимж бэлэглэж байгаа.

### Б.Даваагэрэл: Хүмүүс өөрсдийнхөө хүссэн өнгө, загварын дээлийг урлуулахыг илүүд үзэх болсон

*Сүүлийн үед охид, бүсгүйчүүдийн дунд нэгэн пэйж хуудас “од” болж буй. Тодруулбал, үндэсний их баяр наадамтай холбогдуулан “Наадам 2017” коллекцио танилцуулсан “GereL Fashion” салоны хамт олон. Тус салоныг үүсгэн байгуулагч Б.Даваагэрэл хүүхэд насныхаа хүсэл мөрөөдлийг биелүүлж яваа нэгэн аж. Хүүхэд байхаасаа хувцас, загвар сонирхож, хүсэл мөрөөдлийнхөө төлөө мэргэжлийн сургуульд нь суралцаж төгсчээ. Түүнээс хойш өөрийн нэрийн брэндийг гаргахын төлөө туушатай ажиллаж яваа. Одоогоор нэрийн дэлгүүрээ байгуулахаар тун шаргуу ажиллаж байгаа гэнэ билээ. Түүнтэй энэ жилийн наадмын гоёлын талаар цөөм хором ярилцсанаа хүргэе.*

**-Тун удахгүй наадам болно. Хүмүүс наадын гоёлоо зэхэж байгаа. Зарим нь хаанаас юу авахаа мэдэхгүй эргэлзэж байж ч болох юм. Танай компанийн хувьд наадамд зориулж коллекц гаргасан уу. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?**

-Юуны өмнө салоныхаа талаар мэдээлэл өгсөн нь зөв болов уу. Манай салон хоёр дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ хугацаанд хэрэглэгчиддээ өөрсдийн хийсэн бүтээлийг танилцуулах зорилгоор улирал бүр шинэ коллекц гаргадаг.

**-Танай коллекцийн онцлог юу вэ. Ямар насныханд зориулсан бэ?**

-Манайх шинэ бүтээл гаргахдаа хэрэглэгчдийнхээ хүсэл зорилгыг орчин үеийн загварын чиг хандлагатай хослуулан урладаг. Хамгийн сүүлд “Наадам 2017" нэртэй зуны загварын цуглуулгаа танилцууллаа. Энэ цуглуулгад үндэсний элементийг тусгасан загварын даашинз болон төрөл бүрийн цамцнууд багтсан. Манай салон үндэсний хувцасны элементийг орчин үеийн загвартай хослуулснаар дахин давтагдашгүй бөгөөд баяр наадам, өдөр тутам алинд ч өмсч болохоор энгийн хэрнээ чамин бүтээлүүд гардгаараа онцлогтой.

**-Энэ зун ямар өнгийн дээл трэнд болж байна вэ?**

-Хэрэглэгчдийнхээ санаа бодлыг сонсоход илүү өнгөлөг гэгээлэг, завсарын өнгийг сонгож байгаа харагддаг. Гэхдээ хүмүүс өнгөнд баригдахаа больсон. Илүү өөртөө зохисон, дуртай өнгөө сонгон хэрэглэж байна.

**-Үүнийн хувьд хэдээс хэдэн төгрөгийн хооронд байна вэ?**

-Загвар бүр хийц ажиллагаа, материалаасаа болоод өөр өөр үнэ ханштай. Бид зах зээлийн үнэ ханшийг бодвол хямд боломжийн үнийг хэрэглэгчиддээ санал болгодог.

**-Энэ мэдээллийг уншсан хүмүүс танай коллекцийг сонирхож байвал та бүхэнтэй хэрхэн холбогдох вэ?**

-Одоогоор шинэ гаргасан бүтээлүүдээ цөөн тоогоор бэлэн худалдаалж, ихэвчлэн захиалгаар хийж байгаа. Тиймээс манай “GereL Fashion” пэйж хаягаар болон, 98366398 утсаар бидэнтэй холбондож болно. Цаашид үйлдвэртэй болж хэрэглэгчиддээ илүү хүрч ажиллахын тулд нэрийн дэлгүүртэй болохоор төлөвлөн ажиллаж байна.

### Э.Мандхай: Загвар бүрээс зургаа л урладаг

*“EDEM” брэндийн загварлаг, дэгжин загварын ноолууран бэлэн хувцаснууд бидэнд аль хэдийнэ танил болсон. 2008 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн “Цаст согоот ННК” компани ноос, ноолууран бэлэн хувцас тасралтгүй үйлдвэрлэж ирсэн түүхтэй. Тус компанийн “EDEM” брэнд 2016 оноос нэмэлтээр оёмол бүтээгдэхүүн цөөн тоогоор гаргаж эхэлжээ. Тэгвэл “EDEM” брэндийн хамт олон ч наадмын загваруудаа гаргажээ. Энэ талаар тус компанийн Ерөнхий дизайнер Э.Мандхайтай ярилцсанаа хүргэе.*

**-Үндэсний их баяр наадам тун удахгүй болно. Танай компанийн хувьд наадамд зориулж коллекц гаргасан уу. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?**

-Манай компани үндэсний их баяр наадам болохтой холбогдуулан 20 орчим төрлийн дээл, даашинз, хүрэм гэх мэтчилэн бүтээгдэхүүн гаргаад байна. Загвар бүрээс 3-6 ширхэг гарч байгаа. Мөн загваруудын хувьд А силуэтийг ашиглан материалуудын нийлэмж дээр гар чимэглэлийг түлхүү оруулсан учраас бүсгүйчүүдэд маань их таалагдаж байгаа. Мөн хэт гоёлын гэхээсээ илүү өдөр тутам хүлээн авалт баяр ёслолын үеэр өмсөхөд тохиромжтой бүтээлүүд гарсан.

**-Энэ зун ямар өнгийн дээл трэнд болж байна вэ?**

-Трэнд гэхээсээ илүү монгол загвар маань өөрөө их баялаг учраас маш бага деталыг ашиглаж өдөр тутам өмсч болох дорнын өнгө аястай дүр төрхийг бүтээх боломжтой. Мөн бусад монгол хувцас хийдэг урлан, салонууд өөр өөрсдийн трэнд болгох загвараа танилцуулсан байх. Манай “EDEM” брэндийн хувьд наадмын загвараа хөнгөн нимгэн өмсөхөд тээртэй биш байдлаар шийдэж өгсөнөөрөө онцлогтой.

**-Наадмын коллекцид орсон загварууд хэдэн төгрөгийн үнэтэй вэ. Танай компанид заавал урьдчилж захиалга өгөх ёстой юу?**

-Манай коллекцийн загварууд 200-500 мянган төгрөгийн үнэтэй. Мөн цор ганц гарах загваруудын хувьд өндөр үнэтэй байдаг. Манай бүтээгдэхүүнүүд “Гранд плаза” дэлгүүрийн хоёрдугаар давхарт 2-9 дүгээр тасагт худалдаалагддаг. Бид урьдчилж захиалга авдаггүй. Дэлгүүртээ бэлэн бүтээгдэхүүнээ худалддаг. Зарим тохиолдолд бидний гаргаснаас өөр размер хүсвэл хийж өгдөг. Гэхдээ нэг загвар зургаан ширхэгээс илүү гардаггүй. Тиймээс зургаан ширхэг гарсан загварыг дахин хийх боломжгүй.

NO STRESS

# Урлан: Мэлхий хадны шоно



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 21
Шөнө 12

Нөгөөдөр
Өдөр 24
Шөнө 13

## Өдрийн зурхай

**ЗУНЫ ЭХЭН ХӨХӨГЧИН МОГОЙ САР ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН МОГОЙ ӨДӨР**

**Наран ургах шингэх:** 05.00-20.53

**Үс засуулбал:** Өвчин эмгэг ирнэ



*Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Баяр баясгалангийн хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэх, үйл буруутгах, ламд золгох зэрэг цагаан зүгийн үйлэнд сайн. Баруун нүд татвал холын сураг сонсох, зүүн нь татвал эд олдох, баруун чих хангинавал ундаа олдох, зүүн чих хангинавал түлэгдэх, нохой уливал үхсэний сураг сонсох, хэрээ дуугарвал нөхөртэй учрах, тагнай загатнавал хувцас олдох, бие татвал эцэг, эхэд муу. Хөл татвал хэрүүл, тэмцэл гарах муу ёр болой. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой.*

ДУУЛГАХ СОНИН

## “Дээлтэй Монгол” НААДАМ БОЛНО

Б.БОЛОРТУНГАЛАГ

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар хамтран 11 дэх жилдээ “Дээлтэй Монгол” наадмыг энэ сарын 10-ны өдөр төв талбайд зохион байгуулах гэж байна. Тус наадам нь даяарчлалын зуунд хадгалагдан үлдсэн нүүдэлчдийн соёлын чухал хэсэг болсон Монгол үндэстэн ястны хувцас, гоёл чимэглэлээ дэлхийн нийтэд гайхуулан сурталчлах мөн жуулчдын сонирхлыг татсан томоохон баяр болж өргөжсөн төдийгүй Монголын ирээдүй болсон хүүхэд, залууст түүх, соёл өв уламжлалаараа бахархах ухамсрыг төлөвшүүлэх, таниулах, өвлүүлэх ач холбогдолтой билээ. Наадмын энэ жилийн гол онцлог нь хамгийн том Хүннү дээлийг дэлгэж үзүүлэхээс гадна “Киви” хамтлагийн дуучин Ука ерөнхий дүр төрх болж байгаа бөгөөд ая дуугаа өргөнө. Наадмын үеэр “Монгол костюмс”, “Шилмэл загвар” зэрэг үндэсний хувцасны тэргүүлэх агентлагууд, чөлөөт уран бүтээлчид, үндэсний хувцас урладаг байгууллагууд, ӨМӨЗО-ны Алша аймгийн загвар зохион бүтээгч Шүрнээ нар үндэсний хувцасны коллекцууд танилцуулж уран бүтээлчид ардын урлагийн тоглолт, ёохор хатирах, Хүннүгийн дэвсэх бүжгийг толилуулахаар бэлдэж байгаа аж. Түүнчлэн 22 цагаас Нийслэлчүүд болон Улаанбаатар хотод ирж буй гадаад, дотоодын жуулчдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, тав тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор байгуулагдсан “Шөнийн гэрэлт гудамж”-д Дээлтэй Монгол наадмын хаалт болох “Дээлтэй диско” фашион партиг зохион байгуулах юм байна. Өмнөх жилүүдийн адил Нийслэлийн дүүргүүдийн шилдэг үндэсний хувцастай парад алхах юм байна.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

FOOTBALL NEWS

## Жон Терри доод лигт тоглоно



Английн аваргаар тодорсон “Челси” клубын ахлагч, домогт хамгаалагч Жон Терри багаасаа явсан билээ. Тэгвэл тэрбээр доод лигт тоглож байгаа “Астон Вилла” клубтэй нэг жилийн гэрээ байгуулжээ. Ийнхүү Терри Чемпионшип лигт нэг жил тоглох нь. Терриг “Вест Бромвич”, “Борнмут”, “Брайтон” зэрэг олон баг авахаар сонирхож, санал тавьсан ч тэрбээр “Астон Вилла”-г илүүд үзжээ. Терри шинэ багтайгаа нэгдсэний дараа “Би “Астон Вилла”-д нэгдэж буйдаа баяртай байна. Олон жилийн турш энэ багийг би хүндэлж бишрч ирсэн. “Вилла Парк” бол манай улсын хамгийн шилдэг стадионуудын нэг. Энд сайн баг бүрдэж, туршлагатай, амжилттай ажиллаж яваа Стив Брюс удирдаж байгаа. Ажилдаа хурдхан орж, ирэх улиралд багт тусалж, ямар нэгэн онцгой амжилтад хүрэхийг тэсч ядан хүлээж байна” хэмээн ярьжээ.

## Куадрадог “ПСЖ” клубт 30 саяар худалдах хүсэлтэй байна

Италийн аварга “Ювентус” клубын хагас хамгаалагч Хуан Куадрадо энэ зун багаа өөрчилж магадгүй байна. Турин хотын баг өдгөө 29 настай Колумб тоглогчийг “Челси”-гээс 17 саяар худалдаж авч байсан. Түүнийг “Милан” авах хүсэлтэй байгаа ч “Ювентус” Италийн багт зарахыг хүсэлгүй юм байна. Тэгвэл өнгөрсөн долоо хоногт “ПСЖ” клубын спортын захирал Антеру Энрике “Ювентус”-ын төлөөлөлтэй хэлэлцээр хийж аж. Тэгэхдээ Куадрадог 30 саяар авахад бэлэн гэдгээ илэрхийлжээ.

## Бидэнд тохиолдсон

### ХҮНДХЭН ХӨГТЭЙ ЯВДЛУУД

Д.Зул



Манай нэг найз урд дэлгүүрээсээ гоймон авчихаад орох гэж байж л дээ. Гэтэл байрных нь дээврийн ирмэг дээр нь нэг өсвөр насны охин зогсчихсон байсан гэсэн. Тэгээд “Миний дүү буучих” энэ тэр гэсэн чинь нөгөө охин нь “үгүй үсрэнэ” гээд бөөн цэрэг цагдаа болоод өдөржин цагдаагийн газарт мэдүүлэг өгөөд өнжсөн тухай нь сэтгэл зовнин өөр нэг найздаа ярьсан чинь сонсож сонсож байснаа “тэгээд гоймонгоо яасан гэнэ. Идсэн болов уу гэшш ха ха ха. Хоёулаа группт байдаг юм. Та хоёр гоё шүү гэж хэлье ээ.

## М.Түмэнбаяр “KOREA OPEN 2017”-ООС алтан медаль хүртлээ

БНСУ-ын Чунчон мужид энэ сарын 2-ны өдөр эхэлсэн “Korea Open 2017” Олон улсын тэмцээнд Алдар спорт хороо, Монголын таэквондогийн үндэсний шигшээ багийн тамирчин М.Түмэнбаяр - 58 кг жинд хүч үзэн алтан медаль хүртлээ. Тэрбээр хэсгийн тоглолтуудад БНСУ-ын шилдэг дөрвөн тамирчинг, шигшээ тоглолтод Япон улсын шилдэг тамирчинг хожсоноор жиндээ аваргалж алтан медалийн эзэн боллоо. Мөн Монголын үндэсний шигшээ багийн дасгалжуулагч, багш “Hur Inyon” шилдэг дасгалжуулагч болов. Түүний жинд нийт 59 тамирчин хүч үзсэн юм. Энэхүү алтан медаль нь насанд хүрэгчдийн ангилалд авч Монгол Улсын анхны алтан медаль болж Монголын таеквондогийн спортын түүхэнд нэгэн шинэ хуудсыг нээлээ. Уг тэмцээн нь “G2” ангиллын буюу Олимп, дэлхийн чансааны өндөр оноо олгодог тэмцээн бөгөөд дэлхийн 70 гаруй орны 3000 гаруй тамирчин оролцсон аж.


## ЭРХТЭН СИСТЕМДЭЭ ИХ ЦЭВЭРЛЭГЭЭ ХИЙГЭЭРЭЙ




АНУ –ын 114 жилийн хөгжилтэй UNICITY компанийн ургамлын гаралтай, цэвэрлэгч тэжээл өгөгч UNICITY CLEANSE бүтээгдэхүүнийг уншигч таньд танилцуулж байна. Энэхүү бүтээгдэхүүн нь монголчуудын толгойн өвчин болоод буй өтгөн хаталт болон таргалалтын асуудлыг бүрэн шийдэж, маш сайн үр дүн гаргаад байгаа. Хүний гэдсэнд олон жил хуралдан тогтож чулуужсан 5-40 кг баас шаваадас, 130-аад төрлийн шимэгч үүрлэж байна.

Нэг хүнээс доод тал нь 4-5 төрлийн шимэгч илэрч байгаа нь аюулын харанга дэлдэж байна. Шимэгчийг биеэс гадагшлуулахгүй бол яаж ч жин хассан буцаад жин нэмэгддэг. Шимэгч паразитууд өөрөөсөө хор ялгаруулж хүнийг үхэлд хүргэх аюултай бөгөөд хорт хавдар үүсэх нэг шалтгаан болж байна. Тиймээс таньд UNICITY CLEANCE цэвэрлэгээний төгс бүтээгдэхүүнийг таньд санал болгоё.

**Шимэгч, бактери, хог хаягдлаас биеийг цэвэрлэснээр гарах үр дүн:**

- Ядрахаа болино
- Хөгшрөлтөөс сэргийлнэ
- Харшилд өртөхгүй
- Өтгөн хатах, гүйлгэх, шамбарам зэргээс ангижирна
- Хэт таргалах, Хэт турах,
- Гэдсээрээ бүдүүрэхээс ангижирна
- Дархлаа сайжирч, бактери вирусын халдварт өртөхгүй
- Тууралт загатнаа, батга, хуурайшилт зэрэг арьсны эмгэг засаж, өнгө сайжруулна
- Хоолны шингэц сайжруулна
- Шээс дасагны зовиургүй болно
- Амьсгал биеийн үнэр тааламжтай болно
- Анхаарал төвлөрөл, ой тогтоомж,
- Арьс чангаруулна
- Сэтгэн бодох чадвар сайжирна.
- Архи ,тамхины донтолтгүй болно

**Давуу тал:** Манай бүтээгдэхүүн нь клиник судалгаа хийж батлагдсан албан ёсны зөвшөөрөл, гэрчилгээтэй 100 хувь ургамлын гаралтай дэлхийд танигдсан бүтээгдэхүүн билээ.

**Жич:** АНУ-ын соронзон долгионы аппаратаар эрхтэн системийн 37 үзүүлэлт 250 зүйлээр хямд оношилж байна.

**Манай хаяг: 25-р эмийн сан Кёкүшю цамхаг 7 давхарт 706 тоот. Утас: 99003733, 88961635. Зөвлөгөө мэдээлэл, хүргэлт үнэгүй.**